

## **16. ЗӨГИЙЧИД ХАМТРАХ, НЭГДЭХ БАЙГУУЛЛАГЫН ХЭЛБЭР**



## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

---

16-1. Байгууллагын төрөл .....	243
16-2. Байгууллагын үйл ажиллагааны жишээ .....	244

## 16-1. Байгууллагын төрөл

Монгол орны зөгийн аж ахуй эрхлэгчид ямар нэг бүлэг, байгууллагад харъяалагдан үйл ажиллагаа явуулдаг хүмүүс олон байдаг. Зохион байгуулалттай үйл ажиллагаанд харъяалагдсанаар зөвхөн өөрийн мэдэж чадаагүй технологийн мэдээллийг олж авах төдийгүй зөгийчид тус бүр дангаараа шийдэж чадаагүй борлуулах боломжийг ашиглах боломжтой болно.

”14 Зөгийн балны нийлүүлэлт” болон “15 Нэмүү өртөг”-өөс харахад хамтарч ажилласнаар зөгийн аж ахуйн боломжийг улам өргөжүүлж байна. Монгол улсад хэд хэдэн төрлийн байгууллага, бүтэц зохион байгуулалт байдаг. Ингээд байгууллагын төрөл болоод тус бүрийн онцлог, хууль эрхзүйн зохицуулалтыг авч үзэхийн зэрэгцээ байгууллагын үйл ажиллагааны талаарх бодит жишээтэй танилцъя.

“Бүлэг” бол нийгмийн, үйлдвэрлэлийн, эдийн засгийн, ахуйн, мэргэжлийн, насны, хүйсийн зэрэг нэгдмэл нэг шинжээр яригдах хэсэг тооны хүмүүс, эсвэл юмс хамтдаа нэг газар суурьшсан, цугларсан, ангилагдсан болохыг илтгэнэ.

“Холбоо” гэж тодорхой салбарыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг мэргэжлийн зөвлөмж, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, салбарт төрийн оролцоог багасган, захиргааны чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор ижил төстэй мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, ашгийн төлөө хуулийн этгээд, иргэд хамтран нэгдсэн бодлого, хамтын хяналт, зохион байгуулалттайгаар байгуулсан эрх зүйн хуулийн этгээдийг хэлнэ.

### Хоршоо гэж юу вэ?

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.


Хоршоололд өрсөлдөхийг биш хамтран ажиллаж, амьдрахыг сонгосон хүмүүс л хамрагдан, хэрэгцээнд үндэслэн байгуулдаг. Иргэд, байгууллага хамтарч үйл ажиллагаа явуулна, дундаасаа сонгосон хамтын удирдлагатай, үйл ажиллагааг нь өөрсдөө хянаж зохицуулна, гишүүд хувь хөрөнгөө оруулж санхүүжүүлнэ, улсын бүртгэлтэй албан ёсны байгууллагын хэлбэрээр аж ахуйн үйл ажиллагаа явуулна.

### Төрийн бус байгууллага гэж юу вэ?

Иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага юм.

### Компани гэж юу вэ?

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.



## 16-2. Байгууллагын үйл ажиллагааны жишээ

Төслийн үйл ажиллагаанд оролцож хамтарч ажилласан зөгийн аж ахуй эрхлэгчдийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулья.

### “Органик бал” хоршоо

Сэлэнгэ аймгийн Шаамар суманд үйл ажиллагаагаа явуулдаг. 2014 онд байгуулагдсан ба 14 гишүүнтэй (2022 оны 9-р сарын байдлаар). “Global” олон улсын байгууллагын тусламжтайгаар савлах цех байгуулсан. Одоогоор гишүүн зөгийчдийн зөгийн балыг “Органик бал” хэмээх брэнд бүтээгдэхүүнээр савлан борлуулж байна. Бүх гишүүд үүрэг хариуцлагынхаа хүрээнд эрсдэлээ үүрэх ба менежментийн зохион байгуулалттайгаар бүтээгдэхүүнээ борлуулж гишүүн бүр ашиг олдог.



Зураг: Савлах үйлдвэрийн гаднах байдал (зүүн гар тал), савлах төхөөрөмж (дунд), хоршооны зөгийн бал (баруун гар тал)

### ”Хатан эх” зөгийчдийн холбоо

Дархан-Уул аймгийн зөгийчдийн “Хатан эх” холбоо нь 2017 онд байгуулагдсан. Тус холбоо нь 80 орчим гишүүн зөгийчинтэй (2022 оны 9-р сарын байдлаар). Холбооны гишүүн нь гишүүнчлэлийн хураамж төлөх үүрэг хүлээдэг. Холбоо нь дотроо бүлэг (5 бүлэг)-ийн зохион байгуулалттай байдаг. Мөн “Хатан эх” холбоо нь Монголын Зөгийчдийн Холбоодын Дээд Зөвлөлийн гишүүн байгууллага юм.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 7 гишүүнтэй, улиралд 1 удаа хуралдаж үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийг хэлэлцдэг юм. Харин жилд 1 удаа бүх гишүүдийн хурал зарладаг бөгөөд энд шийдвэр гаргах хамгийн дээд эрхтэй байдаг.

Холбооны хувьд гол үйл ажиллагаа нь технологийн сургалт, мэдээлэл солилцох явдал боловч савлах байгууламж, өвөлжөөний агуулах барихад дэмжлэг хүсч гадаад болон дотоодын засгийн газарт хандан хүсэлт гаргах, барилга байгууламжаа хамтран ашиглах талаар хэлэлцэж байна. Мөн холбооны гишүүдийг малын эмч нартай гэрээ байгуулж, сайн чанарын зөгийн бал үйлдвэрлэхийг уриалдаг.

Холбооны доторх таван бүлэг нь технологийн сургалт хийх, бүлгийн гишүүд болон холбоо хоорондын уялдаа холбоог зохицуулахаас гадна бүлгийн гишүүд зөгийгөө хамтран маллах, бүлэг дотроо зөгийн лаваар лаа хийх, материалаа цуглуулах бусад компаниудтай худалдаа хийх зэрэг ажлыг хариуцан ажилладаг. Бүлэг бүр өөр өөрийн үйл ажиллагааг чөлөөтэй явуулдаг. Семинар болон технологийн сургалт зохион байгуулдаг.

Тус холбоо нь 80%-иас дээш сахарын агууламжтай өтгөн зөгийн бал үйлдвэрлэхийг гол уриа болгон үзэсгэлэн худалдаанд оролцдог.



Зураг: Холбооноос зохион байгуулсан семинар (зүүн гар тал), зөгийчид зориулсан технологийн сургалт (дунд), холбоотой хамтран оролцсон үзэсгэн худалдаа (баруун гар тал)

### Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын “Бүрэн зөгий” бүлэг

“Бүрэн зөгий” бүлэг нь 2018 оноос Зүүнбүрэн сумын зөгийчдийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн, нийт 43 гишүүнтэй юм. (2022 оны 9-р сарын байдлаар) Гишүүнчлэлийн хураамж байхгүй.

Тус бүлгийн хувьд сургалт болон технологийн мэдээлэл зэргийг харилцан солилцдог. 2022 оны зунаас эхлэн бүлгийн ахлагчийн зүгээс зөгийн балны үйлдвэрт зөгийн балаа бөөнөөр нь борлуулах уриалга гаргаж зөвхөн хүсэлт гаргасан зөгийчдийн зөгийн балыг нэгтгэн үйлдвэрт борлуулах үйл ажиллагааг эхлүүлсэн.

Зөгийн балны үйлдвэрт борлуулахад тодорхой хэмжээний буюу түүнээс дээш зөгийн бал нийлүүлэх шаардлагатай байдаг тул бүлгээрээ нэгтгэж цуглуулдаг. Жижиг аж ахуй эрхлэгчид үйлдвэрт борлуулахыг хүссэн ч борлуулж чаддаггүй байсан бол бүлгээрээ нэгдсэнээр борлуулж чаддаг болсон байна. Мөн үйлдвэр нь зөгийн балын чанарын тухайд MNS стандартыг дагаж мөрдөх, балт ургамал нь тодорхой байхыг шаарддаг бөгөөд бүлгийн ахлагч бүлгээсээ чанарын анхан шатны үзлэг хийгээд үйлдвэрт нийлүүлдэг нь үйлдвэртэй харилцан итгэлтэй ажиллах харилцааг бий болгож байна.



Зөгийчид зөгийн балаа нэгтгэж үйлдвэрт нийлүүлэхээр бэлтгэж байгаа нь.